




АРАВ. АЙМАГ, ДҮҮРГИЙН ХОЛБООНЫ ГАЗРЫН ЗОРИЛГО, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГ ҮҮРЭГ

1. Нэр: Аймаг, дүүргийн холбооны газар

1.1. Зорилго: Хариуцсан нутаг дэвсгэрт телефон утас, интернэт, кабелийн телевиз, шугамын байгууламжийн ашиглалт үйлчилгээний хэвийн, шуурхай ажиллагааг хангаж, хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг үзүүлж, улмаар хэрэглэгчдийнхээ тоо, орлогыг тасралтгүй нэмэгдүүлэхийн төлөө ажиллахад оршино.

1.2. Зохион байгуулалтын бүтэц



1.3. Үйл ажиллагааны чиг үүрэг: Дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд: Удирдлага, санхүү бүртгэл, аж ахуйн тасгийн чиг үүрэг:

- Бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны төлөвлөгөө, урьдчилан сэргийлэх, засвар үйлчилгээний ажлын төлөвлөгөө, борлуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллахад зохион байгуулалтын арга хэмжээг авч, хяналт тавих;
- Ажилтнуудын өдөр тутмын үйл ажиллагааг үр дүнтэй, өндөр бүтээмжтэй байдлаар зохион байгуулах;
- Ажилтнуудын ажиллах тав тухтай нөхцөлийг хангах, шаардлагатай багаж сэлбэг хэрэгслээр ханган нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд үр дүнтэй санал гарган, хамтран оролцох, шаардлагатай арга хэмжээг авч ажиллах;
- Хэрэглэгчийн авлага барагдуулалтын сар, улирлын тайлан, мэдээг гарган өмнөх хугацаанаас авлагын дүнг бууруулах;
- Төлбөр тооцооны мэдээг гарган санхүүтэй тулгах, хяналт тавьж ажиллах.

Техникийн ашиглалтын тасгийн чиг үүрэг:

- Хариуцсан нутаг дэвсгэрийн сүлжээ болон кабелийн телевиз, интернэт сүлжээний найдвартай ажиллагааг хангах, хэрэглэгчийн шугамын байгууламжийн урьдчилан сэргийлэх үзлэг, засвар үйлчилгээг гүйцэтгэх, тэдгээрт хяналт тавих;
- Бүтээгдэхүүн үйлчилгээний борлуулалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн ажилд идэвхтэй оролцож хэрэглэгчийн тоог нэмэгдүүлэх;
- Кросс шугамын байгууламжийн техник ашиглалтын чанарын төлөвлөгөөт

даалгаврын биелэлтэд хяналт тавьж, төлөвлөгөөт үзүүлэлтийг ханган биелүүлэх, технологийн картуудыг мөрдөж ажиллах түүний хэрэгжилтэд хяналт тавих;

- Техник, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хянан ажиллах;
- Хэрэглэгчээс ирсэн гомдол санал, сэтгэл ханамжийг судалж, шийдвэрлэн ажиллах;
- Шинээр баригдаж байгаа барилга байгууламжийн нэгдсэн судалгааг тогтмол гаргаж, өөрсдийн сүлжээнд холбох талаар санал тавьж, холбоожуулах талаар хамтран ажиллах;
- Шинэ үйлчилгээ техник технологийн дэвшлийг дэмжин, шилэн кабелийн сүлжээг өргөтгөх, MSAN болон GPON станцыг шинээр сууринуулах нөхцөл бололцоог бүрдүүлэн компанийн газар, албадтай хамтран ажиллах;
- МХС ТӨХХХК-тай хамтран ажиллах, санал солилцох, ашиглалт үйлчилгээ явуулах гэрээний дагуу ажиллах, техник талаас шалтгаалсан асуудалд дүн шинжилгээ хийж, шуурхай хамтын ажиллагааг зохион байгуулах.

Борлуулалт, үйлчилгээний тасгийн чиг үүрэг:

- Харилцаа холбооны бүх төрлийн үйлчилгээг өдөр тутам хэрэглэгчдэд үзүүлэх;
- Үйлчилгээтэй холбоотой хэрэглэгчдийн санал хүсэлтийг хүлээн авч шуурхай барагдуулан холбогдох арга хэмжээг авч, дүгнэлт хийж ажиллах;
- Үйлчилгээтэй холбоотой стандарт, дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт тавих, боловсронгуй болгох санал гаргах;
- Үйлчилгээний хүрээг өргөжүүлэх, зах зээлийн эрэлт хэрэгцээг судлан санал дэвшүүлэх;
- Хэрэглэгчээс суурин утас, интернэт, кабелийн телевизийн шинэ холболтын захиалга авах, гэрээ байгуулах, шилжүүлэх, нэмэлт үйлчилгээний болон бусад төрлийн өөрчлөлтүүдийг хийх, бичиг баримтын материалыг архивын түвшинд бэлтгэх;
- Суурин болон урьдчилсан төлбөрт үйлчилгээний болон интернэт, улс хоорондын бүх төрлийн картын борлуулалтыг гүйцэтгэх;
- Хэрэглэгчийн зах зээлийн судалгаа гарган төлөвийн анализ хийх, холбогдох албадтай хамтран ажиллах;
- Цэгийн тоо, суурь хураамжийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх,
- Бүтээгдэхүүн үйлчилгээг хэрэглэгчдэд сурталчлах, биечлэн танилцуулах;
- Компанийн хэмжээнд хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийг сурталчлах, хэрэгжүүлэх;
- Өөрийн сүлжээний техник, тоног төхөөрөмжийн ашиглалтын түвшний судалгааг тухай бүр хийх, үйл ажиллагааг нэмэгдүүлэх, сайжруулах.